

**АСГАТЫН МӨНГӨНИЙ ОРДЫН НӨӨЦИЙН ТОДОТГОЛ ХИЙХ ЗӨВЛӨХИЙГ
СОНГОН ШАЛГАРУУЛАХ ТЕХНИКИЙН ДААЛГАВАР**

ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Захилагч байгууллагын нэр, хаяг	“Эрдэнэс Монгол” ХХК Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө, Моннис 14-15
Төсөл хэрэгжүүлэх талбай	Баян-Өлгий аймаг, Ногооннуур сум, Асгатын мөнгөний орд газар,
Ажлын нэр	Асгатын мөнгөний ордын нөөцийн тодотгол хийх зөвлөх үйлчилгээ
Ажил гүйцэтгэх үндэслэл	“Эрдэнэс Монгол” ХХК нь Асгатын ордын лиценз эзэмшигч ба стратегийн орд газруудыг эдийн засгийн эргэлтэд оруулах үүргийн хүрээнд Асгатын мөнгөний ордын нөөцийн стандарт, аргачлалыг өнөөгийн Монгол Улсад мөрдөгдөж буй стандартад нийцүүлэн нөөцийг тодотгон тооцох Эрдэс Баялгийн Мэргэжлийн Зөвлөлөөр батлуулах шаардлага үүсээд байна. Асгатын мөнгөний ордын нөөцийг тодотгон тогтоосноор ТЭЗҮ-г боловсруулах, ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах, хөрөнгө оруулалт татах суурь баримт бичиг болно.
Ажил гүйцэтгэх үе шат, цар хүрээ	<ol style="list-style-type: none">1. Хүдрийн судлын кондицийг өнөөгийн стандарт нийцүүлэх, металлын захын агуулгыг дахин тодорхойлох.2. Асгатын мөнгөний ордод 1996 онд хийгдсэн нөөцийн тайлан тооцоог өнөөгийн стандартад нийцүүлэн тодотгон тооцох3. Асгатын мөнгөний ордын нөөцийн тодотгол тооцооны тайланг стандартын дагуу боловсруулах4. Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр нөөцийн тайланг хэлэлцүүлж, нөөц бүртгүүлэх

ТАВИГДАХ ШААРДЛАГА

Чадвар	<ul style="list-style-type: none">- 5-аас доошгүй орд газарт хайгуул судалгааны ажил гүйцэтгэж байсан туршлагатай байх.- 3-аас доошгүй ордын хайгуулын ажлын тайлан материалд тулгуурлан дүн шинжилгээ хийх, нөөц тооцох, тайлан боловсруулах ажлуудыг хийж гүйцэтгэсэн туршлагатай байх. /Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлж, нөөц бүртгүүлж байсан байх/- Геологи хайгуулын чиглэлээр 15-аас доошгүй жил ажилласан туршлагатай мэргэшсэн буюу түүнээс дээш зэрэгтэй геологитой байх.- Геологи хайгуулын мэргэжлийн програм хангамж дээр аналитик судалгаа хийж үр дүнгийн тайлан боловсруулалт хийж байсан туршлагатай байх.- Геологи хайгуулын чиглэлээр 5-аас дээш жил ажилласан, металлын ордын нөөцийн тайлан дээр ажиллаж батлуулж байсан туршлагатай нөөц тооцох мэргэжлийн програм дээр ажилладаг геологичтой байх
--------	---

- 10-аас доошгүй жил ажилласан, үүний 1-ээс доошгүй жил далд уурхайд ажилласан туршлагатай уулын ашиглалтын инженертэй байх

Техникийн шаардлага

- Ажлын үе шат бүрд ажлын процедурыг нарийн тусгасан тайлан, зөвлөмж боловсруулах чадвартай байх
- Тайланг монгол хэл дээр нөөцийн тайлан тооцооны стандартын дагуу бэлдсэн байх.
- Бусад техникийн нэмэлт шаардлагуудыг захиалагч тал гүйцэтгэгчтэй зөвлөлдөж өөрчилж болно.

Тайлан материал хүлээлгэн өгөх

- Гүйцэтгэгч тал нь тухайн ажлыг гүйцэтгэх календарчилсан төлөвлөгөө боловсруулж, танилцуулсан байх
- Бүх шатны ажлыг гүйцэтгэсэн тайлан, анхдагч материал, тоон мэдээлэл, хэвлэмэл зураг зэргийг захиалагч талын хариуцсан мэргэжилтэнд хүлээлгэн өгнө.
- Бүх шатны загварчлал, боловсруулалтуудын үр дүн зэргийг программын орчинд чөлөөтэй хөрвөж байхаар хүлээлгэн өгнө.
- Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, нөөц бүртгүүлсэн тайлангийн эх хувийг хүлээлгэн өгөх.

АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ХУГАЦАА

Ажил эхлэх хугацаа

Ажил гүйцэтгэх гэрээний дагуу